

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ САЛБАР
ДУНДЫН ЗОХИЦУУЛАЛТ, НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ, ГАДААД ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ЛОВУУИГНЭНГИЙН ДУЛАМСҮРЭНГИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, оролцоо, хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах” зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ 1.1. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлтэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	100	Төслийн явц байдалд мониторинг хийх, төсөл хэрэгжиж буй Дундговь аймаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн үйл ажиллагаа, барилгын нөхцөл байдалтай танилцах, аймгийн удирдлагууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй уулзалт хийх зорилгоор Азийн хөгжлийн банкны хяналтын багтай 2024 оны 10 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд Дундговь аймагт албан томилолтоор ажилласан. Барилгын нөхцөл байдалтай танилцаж, тус төвийн барилгын зургийг хариуцан гүйцэтгэсэн “ЭМ ЭС ЭЛ” ХХК-д төвийн барилгын зурагт багц 4 өөрчлөлт оруулж, барилгын зургийг	09 - 12	100

					Барилгын хөгжлийн төвөөр дахин магадлал хийлгэх хүсэлтийг хүргүүлж, Завхан аймагт баригдах төвийн барилгын ажлын зураг, төсөв боловсруулах даалгаврыг ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр батлуулсан. Мөн Завхан аймгийн Улиастай хотод баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга баригдах газарт шугам чөлөөлүүлэх хүсэлт болон Техникийн нөхцөлд ачаалал нэмүүлэх хүсэлтийг “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Завхан аймаг дахь газар болон “Алтай-улиастай эрчим хүчний систем” ТӨХК-ийн Завхан аймаг дахь салбарт албан бичгээр хүргүүлсэн. Баянзүрх дүүрэгт баригдах төвийн газар эзэмших нэр өөрчлүүлэх хүсэлтийг Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатар болон Нийслэлийн хот байгуулалт, хотын стандартын газар, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулах газарт тус тус албан бичгээр хүргүүлсэн. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар 5 Үнэлгээний хороог байгуулсан.		
--	--	--	--	--	---	--	--

Дэд арга хэмжээ 1.1.1. Тендерийн үнэлгээний хороо байгуулах, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

Хэрэгжилтийн хувь

-

100

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар дараах Үнэлгээний хороог байгуулсан. Үүнд:

1. С24 дугаартай Хүртээмжийн хувь зөвлөх, С25 дугаартай “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах” хувь зөвлөхийг тус тус сонгон шалгаруулах үнэлгээний хороог 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А/78 тоот тушаалаар;

2. G13 дугаартай Эрт илрүүлгийн аргачлал болон хүүхдийн ягаан дэвтэр хэвлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/100 тоот тушаалаар;

3. Тушаалд өөрчлөлт оруулах тухай 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/108 тоот тушаал

4. Төслийн нэгжийн Хөгжлийн бэрхшээлийн асуудал хариуцсан мэргэжилтнийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/165 тоот тушаалаар;

5. Тушаалд өөрчлөлт оруулах тухай 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/170 тоот тушаалаар;

09 - 12

100

Дэд арга хэмжээ 1.1.2. Төслийн нэгжээс холбогдох байгууллага, хамтран ажиллагч талуудад дэмжлэг үзүүлэх;	Хэрэгжилтийн хувь	-	100	Завхан аймгийн Улиастай хотод “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийн барилга барихтай холбогдуулан дараах байгууллагуудад албан бичгээр хүсэлт гаргасан. Үүнд: 1. Техникийн нөхцөлд ачаалал нэмэх, цахилгаан дамжуулах шугам зөөлгөх хүсэлт гаргах тухай албан бичгийг Завхан аймаг дахь “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн газар болон “Алтай-улиастай эрчим хүчний систем” ТӨХК-ийн Завхан аймаг дахь салбарт хүргүүлсэн. 2. Төвийн барилгын зургийг гүйцэтгэсэн “ЭМ ЭС ЭЛ” ХХК-д төвийн барилгын зурагт багц 4 өөрчлөлт оруулж, барилгын зургийг Барилгын хөгжлийн төвөөр дахин магадлал хийлгэх хүсэлтийг хүргүүлсэн. Баянзүрх дүүрэгт “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийн барилга барихтай холбогдуулан дараах байгууллагуудад албан бичгээр хүсэлт гаргасан. Үүнд: 1. Архитектур төлөвлөлтийн даалгавар хүсэх тухай албан бичгийг Нийслэлийн хот байгуулалт, хотын стандартын газарт 2. Газрын эзэмшигчийн нэр өөрчлүүлэх хүсэлтийг Нийслэлийн Засаг дарга Х.Нямбаатар болон Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд 2024 оны 10	09 - 12	100
--	--------------------------	----------	------------	---	----------------	------------

					дугаар сарын 23-ны 03/952 тоот албан бичгээр хүргүүлсэн. 3. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулах газарт газар эзэмших нэр өөрчлүүлэх хүсэлтийг хүргүүлсэн. Төслийн нэгжийн үйл ажиллагаатай холбогдуулан дараах байгууллагад албан бичгийг боловсруулж, хүргүүлсэн. Үүнд: 1. Төслийн нэгжийн зөвлөх үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж буй ЭМ СИ ДИ ЭС КОНСАЛТАНИСИ ХХК-д үйл ажиллагааны тайлан ирүүлэх тухай албан бичиг; 2. Төслийн нэгжийн Санхүүгийн ажилтныг томилж өгөх хүсэлтийг Сангийн яаманд; 3. Төслийн нэгжийн Санхүүгийн ажилтан, жолоочоор томилогдсон албан хаагчдын цалин тогтоолгох хүсэлтийг Сангийн яаманд; 4. Эрүүл мэндийн яам руу “Хүүхдийн хөгжлийн урьдчилан сэргийлэх үзлэгийн гарын авлага” (дэлгэрэнгүй зааварчилгаа)-ын төсөлд санал авах тухай албан бичиг.		
	Дэд арга хэмжээ 1.1.3. Төслийн удирдах хороог шинэчлэн батлуулах, удирдах хорооны хурлыг зохион байгуулах;	Хэрэгжилтийн хувь	-	100	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг Гэр бүл,	09 - 12	100

					хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/46 тоот тушаалаар шинэчлэн батлуулсан. Төслийн нэгжийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраар үнэлүүлж, Удирдах хорооны хурлаар гишүүдэд танилцуулах бөгөөд хурлыг 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хийхээр төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна.		
2	Арга хэмжээ 1.2. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-тай хамтран хэрэгжүүлж буй Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,	Хэрэгжилтийн хувь	-	100	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төслийн үйл ажиллагааны тайлангийн хурлыг 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Мөн тайлангийн хурлаар “Монгол Улсад шаардлагатай нийгмийн хамгааллын тогтолцоо ба олон улсын хамтын ажиллагааны боломж” сэдэвт симпозиумыг зохион байгуулсан. Удирдах зөвлөлийн 8 дахь удаагийн хурлыг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт зохион байгуулсан. Уг хурлаар төслийн 4 жилийн үйл ажиллагааны ерөнхий тайлан, хяналтын хуудсыг баталж, төслийн	09 - 12	100

				үр дүн Монгол Улсад нутагшуулах зөвлөмжийн төслийг хэлэлцүүлсэн. Төслийн тэргүүлэх зорилгод хүрэхэд шаардлагатай зөвлөмжийг Ахлах зөвлөх Чиба Хисао боловсруулж, Монгол Улсын Засгийн газарт Ажил олголтын квот ба Ажлын байрны төлбөрийн тогтолцоотой холбоотой зөвлөмж, Ажлын байрны дадлагажуулагчийн санхүүгийн дэмжлэгийн тогтолцоотой холбоотой зөвлөмж, Ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг орон нутагт түгээн дэлгэрүүлэх стратегитэй холбоотой зөвлөмжийг тусгаж 2024 оны 10 дугаар 29-ний өдөр тус яаманд хүлээлгэн өгсөн.		
Дэд арга хэмжээ 1.2.1. Төслийн удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллах;	Хэрэгжилтийн хувь	-	100	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төслийн үйл ажиллагааны тайлангийн хурлыг 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Тайлангийн хурлаар төр, хувийн хэвшлийн ААНБ, ажлын байрны дадлагжуулагч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын 100 гаруй оролцогчдод төслийн 4 жилийн үйл ажиллагааг танилцуулж, ажлын байрны дадлагажуулагчийн дэмжлэг үзүүлсэн бодит жишээ, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн сайн жишээг танилцуулсан. Мөн	09 - 12	100

				тайлангийн хурлаар “Монгол Улсад шаардлагатай нийгмийн хамгааллын тогтолцоо ба олон улсын хамтын ажиллагааны боломж” сэдэвт симпозиумыг зохион байгуулсан. Удирдах зөвлөлийн 8 дахь удаагийн хурлыг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газарт зохион байгуулсан. Уг хурлаар төслийн 4 жилийн үйл ажиллагааны ерөнхий тайлан, хяналтын хуудсыг баталж, төслийн үр дүн Монгол Улсад нутагшуулах зөвлөмжийн төслийг хэлэлцүүлсэн. Төслийн тэргүүлэх зорилгод хүрэхэд шаардлагатай зөвлөмжийг Ахлах зөвлөх Чиба Хисао боловсруулж, Монгол Улсын Засгийн газарт Ажил олголтын квот ба Ажлын байрны төлбөрийн тогтолцоотой холбоотой зөвлөмж, Ажлын байрны дадлагажуулагчийн санхүүгийн дэмжлэгийн тогтолцоотой холбоотой зөвлөмж, Ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг орон нутагт түгээн дэлгэрүүлэх стратегитэй холбоотой зөвлөмжийг тусгаж 2024 оны 10 дугаар 29-ний өдөр тус яаманд хүлээлгэн өгсөн.		
Дэд арга хэмжээ 1.2.2. Удирдах зөвлөлийн хурлаар төслийн эцсийн	Хэрэгжилтийн хувь	-	100	Удирдах зөвлөлийн 9 дэх удаагийн хурлыг 2024 оны 12 дугаар сард	09 - 12	100

	тайланг хүлээн авах ажлыг зохион байгуулах;				зохион байгуулахаар ажиллаж байна.		
Зорилт 2. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх үндэсний зөвлөл болон дэд салбар зөвлөлийн үйл ажиллагааны зохицуулалтыг хариуцах” зорилтын хүрээнд							
3	Арга хэмжээ 2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, хэлэлцүүлэх;	Журмын төслийг шинэчлэн боловсруулсан байна.	-	1	Засгийн газрын 2023 оны “Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 402 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 30 гаруй ТББ-тай уулзалтыг зохион байгуулж, саналыг тусган Тогтоолын төсөл, танилцуулга, журмын төслийг тус тус боловсруулж, удирдлагуудад танилцуулан санал авч байна.	09 - 12	100
	Дэд арга хэмжээ 2.1.1. Журмын төсөлд төрийн бус байгууллагуудын саналыг авч нэгтгэх, хэлэлцүүлэг зохион байгуулах;	Хэрэгжилтийн хувь	-	100	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 2/680 тоот албан бичгээр Журмын төсөлд тусгах саналыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 20 ТББ-аас авч, нэгтгэж ирүүлсэн. Ирүүлсэн саналыг журмын төсөлд тусгаж, 2024 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр ХБХХЕГ-т 30 гаруй ТББ-ын төлөөлөлтэй уулзаж, саналыг танилцуулж, журмын төслийг хэлэлцүүлсэн.	09 - 12	100

	Дэд арга хэмжээ 2.1.2. Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авах;	Хэрэгжилтийн хувь	-	100	Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг журмын төслийн хамт боловсруулж, яамны удирдлагуудаас саналыг авч нэгтгэж байна. Төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авах албан бичгийг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн дотор хүргүүлэхээр ажиллаж байна.	09 - 12	100
4	Арга хэмжээ 2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах;	Тайлагналт - 1	-	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд 16 арга хэмжээ, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээг сайжруулах хүрээнд 12 арга хэмжээ, нийт 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан. Дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг харьяа газар, хэлтсүүдээс авч, тайланг нэгтгэж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/44 тоот тушаалаар байгуулагдсан дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулахаар тушаалын төслийг боловсруулж, дэд зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлтгэж байна.	09 - 12	100
5	Арга хэмжээ 2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй Оны шилдэгийг шалгаруулах арга	Арга хэмжээний тоо	-	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2019 оны 01 тоот	09 - 12	100

	хэмжээг ХБХХЕГ-тай хамтран зохион байгуулах;				тушаалаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэгийг шалгаруулах журам”-ын дагуу 2024 оны шилдэг шалгаруулах арга хэмжээг дараах төрлөөр сонгон шалгаруулж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн ордонд шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: - Оны шилдэг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөл - Зам тээврийн яам - Оны шилдэг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөл - Сонгинохайрхан дүүрэг - Хөгжлийн бэрхшээлтэй хүний манлайлагч төрийн бус байгууллага - “Эрхэм нандин сувд” ТББ - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй оны шилдэг боловсролын байгууллага - Дорнод аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын Хан-Уул сургууль - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг эрүүл мэндийн байгууллага - Улсын гуравдугаар төв эмнэлэг - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллага - Таван Богд Фүүдс Пицца		
--	--	--	--	--	--	--	--

					- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг хэвлэл - Централ телевиз - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй бүтээн байгуулалт - Улсын төв номын сан - Хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөө нийгмийн зүтгэлтэн - Н.Оюунбат		
6	Арга хэмжээ 2.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;	Хэрэгжилтийн хувь	-	100	Монголын хараагүйчүүдийн холбооноос Дэлхийн цагаан таягтны өдрийг угтаж “Хараагүй хүмүүсийн чадавхи, хүртээмжтэй орчныг сурталчлан дэмжих, дэд бүтцийг сайжруулах” уриан дор 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан уулзалт өдөрлөгт оролцож, нийгмийн халамжийн чиглэлээр иргэдэд мэдээлэл хүргэж, хамтран ажилласан. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгууллагуудын шүхэр нэгдсэн бодлогын зөвлөл”-өөс 2024 оны 12 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд зохион байгуулах “Гарц шийдэл” хэлэлцүүлгийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. “Тэгш Тусгал” ТББ-ын хэрэгжүүлж буй Монголын сонсголгүй иргэдийн хэлний адилслыг бэхжүүлэх төслийн хүрээнд “Монгол дохионы хэлний цахим толь бичиг” нээлтийн үйл	09 - 12	100

					ажиллагаанд 11-р сарын 20-ны өдөр оролцсон. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 30 гаруй ТББ-тай 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, саналыг тусган журмын төслийг боловсруулсан. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/44 тоот тушаалаар байгуулагдсан дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулахаар зөвлөлийн бүрэлдэхүүн дэх төрийн бус байгууллагын төлөөллөөс саналыг авсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн бүрэлдэхүүн дэх төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж, зарим яамдын дэд зөвлөлийн үйл ажиллагааны сонсгол зохион байгуулах удирдамжийг хамтран боловсруулж, дэмжлэг үзүүлж ажилласан.		
7	Арга хэмжээ 2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зарим дэд зөвлөлийн үйл ажиллагааны сонсголыг хамтран зохион байгуулах;	Хэрэгжилтийн хувь	-		Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх дэд зөвлөлийн үйл ажиллагааны сонсголыг зохион байгуулах	09 - 12	100

					удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар батлуулж, холбогдох яамдуудад албан бичгээр хүргүүлсэн. Уг сонсголыг 2024 оны 12 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулах бөгөөд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам зэрэг 6 яам үйл ажиллагаагаа танилцуулна.		
Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд							
8	Арга хэмжээ 3.1. Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг тус тус хэрэгжүүлж, ажиллах;	Хэрэгжилтийн хувь	100	100	“Авлигын эсрэг хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.3. “Мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн алба хааж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй” гэж заасны дагуу 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд бүрэн мэдүүлсэн.	09 - 12	100
9	Арга хэмжээ 3.2. Хариуцсан асуудлын чиглэлээр хуулийн төсөл, УИХ, ЗГ-ын тогтоолын төсөлд санал	Бодлогын үндэслэлтэй	-	100	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах арга хэмжээний	09 - 12	100

	өгөх, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах, хууль, тогтоол шийдвэрийн төсөлд салбарын бодлогыг тусгасан санал боловсруулж, танилцуулах;	санал өгсөн байна.			саналыг яамны газар, хэлтсүүдээс нэгтгэн авч, 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 01/47 тоот албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус хэлтсээс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, тайлбар, үндэслэлийг хэлтсийн албан хаагчидтай хамтран боловсруулж, 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр холбогдох газарт хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн “Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль”-ийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд санал тусгаж, Төрийн захиргаа удирдлагын газарт 2024 оны 11 дүгээр сард хүргүүлсэн. Тайлант хугацаанд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газрын тогтоолоор батлагдсан холбогдох журмыг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий дараах Ажлын хэсэгт ажилласан. Үүнд:		
--	--	---------------------------	--	--	---	--	--

					1. ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/160 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журмыг шинэчлэн боловсруулж, 2, 3 дугаар хавсралтаар батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын төслийг боловсруулж, яамдуудаас санал авахаар албан бичгээр хүргүүлсэн. 2. ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/122 тоот тушаалаар байгуулагдсан Засгийн газрын 2021 оны 363 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопед болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ тогтоох тухай”, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт олгох журмыг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчныг бий болгоход чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд Саадгүй байдал, хүртээмжийн тухай хууль,		
--	--	--	--	--	--	--	--

					Дохионы хэлний тухай хууль, Бие даан амьдрах, нөхөн сэргээх үйлчилгээний тухай анхдагч хуулийн төсөл, Туслах технологийн үндэсний стратегийг тус тус боловсруулах Ажлын хэсгийг байгуулахаар холбогдох яамд руу 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 03/1134 тоот албан бичгийг хүргүүлсэн. Хүний эрхийн үндэсний комиссоос хэрэгжүүлж буй “Цахим хөгжлийн хүртээмж, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон ахмад настанд зориулсан туслах цахим технологийн бодлого, зохицуулалт” судалгааны хүрээнд туслах цахим технологийг хэрэглэх ур чадварыг хөгжлийн бэрхшээлтэй хүн болон ахмад настанд эзэмшүүлэх чиглэлээр хийгдэж байгаа бодлого, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах, ярилцлага хийхэд хамтран ажиллахаар нэр хүргүүлсэн.		
10	Арга хэмжээ 3.3. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариуг хүргүүлэх;	Шийдвэрлэлт ийн хувь	-	100	Албан хэрэг хөтлөлтийн erp.mlsr.gov.mn цахим системээр ирүүлсэн хариутай 4, хариугүй 15, нийт 19 албан бичиг, иргэнээс ирүүлсэн 10 өргөдлийг хүлээн авч, хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж, хариуг хүргүүлж ажилласан. Төрийн албаны зөвлөлөөс 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн албан бичгээр ирүүлсэн Монгол	09 - 12	100

					Улсын төсвийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар төрийн албаны чадавх бэхжүүлэх чиглэлээр хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг загвар хүснэгтийн дагуу боловсруулж, хүргүүлсэн.		
11	Арга хэмжээ 3.4. Тайлан мэдээний батлагдсан хуваарийн дагуу хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, бодлогын баримт бичиг болон өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, бусад мэдээ, судалгааг нэгтгэн тайлагнах;	Хугацаанд нь тайлагнасан байна.	-		Хэлтсийн тайлангийн батлагдсан хуваарийн дагуу дараах тайланг нэгтгэж, хугацаанд нь хүргүүлсэн. Үүнд: 1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2024 оны 10 дугаар сарын хэрэгжилт; 2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан тус хэлтсийн хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт; 3. Хэлтсийн 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт; Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилтийг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайлагнахаар ажиллаж байна. Улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн 2024 оны хэрэгжилтийг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тайлагнахаар биелэлтийг нэгтгэж байна.	09 - 12	100

12	Арга хэмжээ 3.5. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны холбогдох хууль, дүрэм, журам, стандартын шаардлага, хэрэгжилтийг хангаж, баримт бичгийг хөтлөн явуулах, архивын нэгж үүсгэх;	Баримт бичгийг стандартын дагуу боловсруулан хөтөлж, архивт хүлээлгэн өгсөн байна.	-		Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн хүрээнд 18 албан бичгийг боловсруулан удирдлагуудаар хянуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Мөн тайлант хугацаанд орон нутагт ажиллах 3 удаагийн удирдамж, төсвийг боловсруулж, албан томилолтын тайланг яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газарт тайлагнасан. 2024 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан тушаалын чиг үүргийн хүрээнд хадгаламжийн нэгжийг үүсгэж, хуулийн хугацаанд холбогдох газарт хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.		
----	---	--	---	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. ХНХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, халамж, асрамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилт, зохицуулалт хариуцсан мэргэжилтнээр ажиллах хугацаанд хийж гүйцэтгэсэн ажил	Хэрэгжилтийн хувь	-	100	Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг УИХ-аас 2024 оны 6 сарын 5-ны өдөр баталж, 2025 оноос эхлэн хэрэгжүүлэхээр болсон. Иймд дээрх хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Засгийн газрын тогтоолоор батлагдсан дараах журмын төслийг шинэчлэн боловсруулсан. Үүнд: 1. Засгийн газрын 2017 оны 31 дүгээр тогтоолоор батлагдсан “Насны хишиг олгох журам”,	07-10	100

				2. Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох журам, <u>Нэмэлт, өөрчлөлт оруулсан журмын төсөл:</u> 3. Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”, 4. Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулж, ХХҮЕГ, аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдээс санал авч, нэгтгэсэн. “Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгын хамт боловсруулж, яамны удирдлагуудад танилцуулж, саналыг тусган эцэслэж, төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авах албан бичгийг хүргүүлсэн. Мөн Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийн сайд болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын		
--	--	--	--	---	--	--

				сайдын хамтарсан тушаалаар батлах “Ахмад настны цогц үнэлгээ хийх, цогц тусламж үйлчилгээ үзүүлэх журам, мэргэжлийн удирдлагын заавар, үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын төслийг боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, Эрүүл мэндийн яам, Герентлогийн үндэсний төв, Монголын ахмадын холбооноос санал авч, журмын төслийг хамтран боловсруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 363 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийгмийн халамжийн сангаас олгох протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнэ”-ийг шинэчлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/160 тоот тушаалаар баталсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн дэх Төрийн бус байгууллагын төлөөлөлтэй 2024 оны 08 дугаар 13-ны өдөр, Сэргээн засах, сургалт үйлдвэрлэлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах эмнэлгийн холбогдох албан хаагчидтай 2 удаагийн		
--	--	--	--	--	--	--

				уулзалтыг зохион байгуулж, протез, ортопедийн болон тусгай хэрэгслийн жагсаалт, жишиг үнийг шинэчлэн боловсруулсан. Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хүнд хэлбэрийн хавсарсан эмгэгтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 2025 оноос эхлэн живхний үнийн хөнгөлөлт олгохтой холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт”-ын дагуу хөгжлийн бэрхшээлтэй 12, 077 хүүхдийн судалгааг өвчний жагсаалт бүрээр гаргаж, үүнээс хоёроос дээш насны живх байнга хэрэглэдэг хөгжлийн бэрхшээлтэй 3,009 хүүхдийн судалгааг нэгтгэн гаргасан. ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлогод үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах судалгааны зөвлөх Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын даалгаврыг баталсан. Уг ажлын хүрээнд “Асрамжийн үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид үйлчилгээг сайжруулах зөвлөмж”-ийг боловсруулж, Ажлын хэсгийн	
--	--	--	--	---	--

					бүрэлдэхүүнд 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр танилцуулсан. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний 2024 оны хагас жилийн байдлаарх хэрэгжилтийг гэрээлэн гүйцэтгэсэн байгууллага, гэрээлсэн байгууллагад олгосон санхүүжилтээр гаргаж, нэгтгэсэн.		
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтсан аяны хүрээнд				Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн ордонд зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо” үндэсний чуулганыг зохион байгуулах Ажлын хэсэгт ажиллаж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хийж гүйцэтгэсэн. Мөн Олон Улсын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн өдрийн хүрээнд тус яамнаас “Хайнд про” ХХК-тай хамтран 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсан “ABILITY EXPO 2024” хөдөлмөрийн нэгдсэн яармаг, өдөрлөгт оролцсон.	09-12	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар				Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын талаарх	07-12	100

	холбогдох хууль эрх зүй, дүрэм, журмыг судлах, судалгааны баримт материалтай танилцах;				ойлголт, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос Монгол Улсын Засгийн газарт ирүүлсэн зөвлөмжийг танилцуулах сургалтад хамрагдсан. Бодлогын баримт бичиг төлөвлөх, салбарын холбогдох хууль, журамд санал боловсруулах Ажлын хэсгүүдэд ажиллаж, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн. Тайлант хугацаанд хуулийн төсөлд 3, журмын төсөлд 8, дүрмийн төсөл 2, гэрээний төсөлд 1, аргачлалын төсөлд 1, нийт 12 саналыг тус тус боловсруулж, санал тусгасан.		
2.	Арга хэмжээ 2. Мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр зохих сургалтад хамрагдах, олон нийтийн ажилд идэвхтэй оролцох;				Төрийн албаны тусгай шалгалтад бэлтгэх зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс 2022-2024 онд зохион байгуулсан “7:4:10 Вебинар цахим сургалт”-ын хүрээнд Төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн албаны шинэтгэл, Манлайлал, Удирдан зохион байгуулах чадвар, багаар ажиллах менежмент сэдэвт цахим сургалтыг нөхөн судалсан. Мөн Төрийн албаны тусгай шалгалтын хууль эрх зүй, бодлогын баримт бичгийн мэдлэг шалгах агуулгын хүрээнд Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого болон холбогдох 10 гаруй хууль тогтоомжийг уншиж судалсан. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан тул Бизнес	07-12	100

				консалтинг төвийн сургалтад бүртгүүлж, tender.gov.mn сайтад цахимаар шалгалт өгөх хүсэлт гаргасан. Тайлант хугацаанд дараах олон нийтийн ажилд хамрагдсан байна. Үүнд: 1. Монгол Улсын Шадар сайдын баталсан бодлого, төлөвлөгөөний дагуу Онцгой байдлын ерөнхий газраас 2024 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдөр зохион байгуулсан Хүн ам, нийгмийн хамгааллын улсын албанд зохион байгуулж байгаа /Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам/ гамшгаас хамгаалах команд штабын дадлага сургуулилтад холбогч гишүүний үүргийг гүйцэтгэж оролцсон. “Засгийн газрын цом-2024” спортын таван төрөлт тэмцээн 2024 оны 11 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулагдаж гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннисний төрөлд оролцсон.		
--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний салбар дундын зохицуулалт, нийгмийн түншлэл, гадаад төсөл, хөтөлбөрийн бодлого төлөвлөлт хариуцсан шинжээч
(Албан тушаал)

.....
(Нэр, гарын үсэг)

/Л.Дуламсүрэн/

2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

(Огноо)